

## **МАЛЫН БЭЛЧЭЭРИЙН БҮСЭЭС БУСАД ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ БҮСЭД МӨРДӨХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл:**

- 1.1 Дархан сумын малын бэлчээрийн бүс болоод мал бэлчээхийг хориглосон суурьшлын бүс нь байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ач холбогдолтой нутаг дэвсгэр мөн бөгөөд тус сумын нутаг дэвсгэрийн газрыг зүй зохистой ашиглах, байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах, хотын ногоон байгууламжийг хамгаалах, суурьшлын бүсэд хүн амьдрах эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг хангуулах зорилгоор мал бэлчээх бэлчээрийн бүсийг тогтоож зөвшөөрснөөс бусад бүсэд явсан малыг хаших, түүнтэй холбоотой гарсан зардлыг нөхөн төлүүлэх, зөрчил гаргагчдад хариуцлага тооцохтой холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

### **Хоёр. Малын бэлчээрийн бүс**

- 2.1 Дархан сумын дараах бүсэд мал бэлчээхийг зөвшөөрнө.  
2.1.1 Дархан сумын 6, 8, 15, Малчин багийн нутаг дэвсгэр

### **Гурав. Мал бэлчээхийг хориглох бүс**

- 3.1 Дархан сумын дараах бүсэд мал бэлчээхийг хориглоно.  
3.1.1 Энэ журмын 2 дугаар зүйлийн 2.1-д заасан бүсээс бусад суурьшлын бүс.

### **Дөрөв. Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүрэн эрх**

- 1.1 Малын бэлчээрийн бүсээс бусад зөвшөөрөгдөөгүй бүсэд мөрдөх журамд өөрчлөлт оруулах, хүчингүй болгох.  
1.2 Журмын хэрэгжилтийн талаарх сумын Засаг даргын хагас, бүтэн жилийн үйл ажиллагааны тайланд үнэлэлт дүгнэлт өгөх.

### **Тав. Малчин, мал бүхий этгээдийн эрх, үүрэг**

- 5.1 Малчин, мал бүхий этгээдийн эрх:  
5.1.1 Энэ журмын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасан бүсэд малаа бэлчээх.

5.1.2 Энэ журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасан бүсэд малаа хариулгатай бэлчээх.

5.1.3 Мал, тэжээвэр амьтныг хашиж журамлах хугацаанд үзүүлсэн үйлчилгээ, бүртгэл, тэмдэглэлтэй танилцах.

5.2 Малчин, мал бүхий этгээдийн үүрэг:

5.2.1 Малаа бэлчээрийн бүсээс дотогш суурьшлын бүсрүү бэлчээхгүй байх бүх талын арга хэмжээг авах.

5.2.2 Малчин, мал бүхий этгээд нь өөрийн малыг журмын хашаанд байгааг мэдмэгц тэдгээрийг журмын хашаанаас гаргах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх.

5.2.3 Мал хашиж журамлахтай холбогдон гарсан зардлыг төлөх.

5.2.4 Хууль тогтоомжид заасан бусад шаардлагыг биелүүлэх.

### **Зургаа. Мал амьтдыг дараах тохиолдолд хашиж журамлана.**

6.1 Энэ журмын 3 дугаар зүйлийн 3.1-д заасан хориглох бүсэд эзэн хариулгагүй явсан, нэвтрэн орсон мал, тэжээвэр амьтныг.

6.2 Хориглох бүсэд байгаа ногоон байгууламжийг хугалж гэмтээх, талхлах, идэж гишгэлэх зэргээр хохирол учруулсан мал, тэжээвэр амьтныг хашиж журамлана.

### **Долоо. Мал, тэжээвэр амьтдыг хашиж журамлах үйл ажиллагаа**

7.1 Энэ журмын 6 дугаар зүйлд заасан нөхцөл байдал бий болсон тохиолдолд Нийтийн аж ахуй үйлчилгээний газар нь малыг хашиж журамлах ажлыг зохион байгуулалтаар хангах.

7.2 Малыг хашиж, журамлах газарт ирсэн мал, амьтныг НААҮГ-ын амьтан маллагч хүлээж авах бөгөөд малын нэр төрөл, хүйс, зүс, тоо, хүлээн авсан цаг хугацаа, малын шинж тэмдгийг нэг бүрчлэн бичиж бүртгэл үйлдэн хүлээлгэн өгсөн этгээдээр гарын үсгийг зуруулж баталгаажуулан хүлээлцэнэ.

7.3 Журамлагдан ирсэн малыг эрүүл ахуйн шаардлага хангасан газарт мал хаших зориулалтын хашаанд хашина.

7.4 24 цагаас дээш хугацаагаар хашигдсан мал бүрт хоногт идэх өвс, уух усны нормыг баримтлан өдөрт 2-оос доошгүй ус тэжээл өгч тухай бүрт бүртгэл үйлдэнэ.

7.5 Ажлын цагаар журамлагдан ирсэн мал, амьтанд мал эмнэлгийн нэгжийн эмч үзлэг хийж хүлээн авна.

7.6 Ажлын бус цагаар журамлагдан ирсэн мал, амьтан нь гадны ямар нэг гэмт халдлагад өртсөн шинж тэмдэгтэй байж болзошгүй нөхцөлд Цагдаагийн газрын жижүүрт мэдэгдэн газар дээр нь үзүүлж шинж тэмдэг бүрийг бүртгэлийн дэвтэрт бүртгэж гарын үсэг зуруулах бөгөөд дараа өдрийн ажлын цаг эхэлмэгц нэн яаралтай малын эмч үзлэг хийнэ.

7.6 Энэ журмын 7 дугаар зүйлийн 7.3, 7.4, 7.5, 7.6 дахь заалтуудын дагуу ажилласан нөхцөлд тухайн мал түүнээс гарсан төл үхвэл хашиж журамласан байгууллага, ажилтан хариуцлага хүлээхгүй.

7.7 Үхсэн малыг ажлын 24 цагийн дотор малын эмчид, малын эмч байхгүй тохиолдолд сумын мал эмнэлгийн тасагт мэдэгдэж дүгнэлт, акт гаргуулна.

#### **Найм. Нийтэд зарлан мэдэгдэж мал, амьтдын эзнийг тодруулах.**

8.1 Хашиж журамласан мал амьтдыг Дархан сумын ЗДТГ хариуцан зар мэдээний самбарууд болон мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдэгдэнэ. Зарлалыг мал амьтадыг журамлагдсан өдрөөс эхлэн хариуцагч нь тогтоогдох хүртэл зарлуулна.

8.2 Хашиж журамлагдсан мал, амьтны эзнийг тогтоохоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлуулснаас хойш 3 хоногийн дотор эзэн нь тогтоогдоогүй бол цагдаагийн байгууллага эзнийг тогтооно.

8.3 Зарлалын дагуу малаа авахаар ирсэн эзний бичиг баримтыг үндэслэж зөрчлийн тэмдэглэл хөтлөн гарын үсэг зуруулж хүлээлгэн өгнө. Ингэхдээ малыг зөвхөн эрх зүйн чадамжтай этгээдэд зохих хариуцлага тооцож, хашиж журамлахтай холбоотой гарсан зардлыг бүрэн төлсний дараа олгоно.

#### **Ес. Мал, амьтдыг хашиж журамлахтай холбогдон гарсан зардал**

9.1 Малыг хашиж журамлагдсан мал амьтны эзнийг тодорхой болтол тэдгээрийг хадгалж, арчилж хамгаалахтай холбогдон гарсан зардлыг малчин, мал бүхий этгээдээр төлүүлнэ.

9.2 Малыг хашиж журамлахтай холбогдон гарсан зардлыг тогтоохдоо:

- Өвс тэжээлийг зах зээлийн ханшаар

- 1 литр усыг 2 төгрөгөөр тооцно.

- Малыг хашиж журамласан хоног тутамд бог мал нэг бүрт 3000 төгрөг, бод мал нэг бүрт 5000 төгрөгөөр тооцож хураамж төлнө.

9.2 Энэ журмын 3 дугаар зүйлд заасан мал бэлчээхийг хориглосон бүсэд мал орсныг мэдээлэлсэн иргэнд бог мал нэг бүрээс 1000 төгрөг, бод мал нэг бүрээс 3000 төгрөгөөр тооцож урамшуулал олгоно.

9.3 Мал амьтныг хадгалж хамгаалахтай холбогдон гарсан зардлыг төлсөн нь захиргааны хариуцлага хүлээлгэхээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

#### **Арав. Гомдол гаргах эрх**

10.1 Малыг хашиж журамлах үйл ажиллагаа, түүнтэй холбоотой гарсан зардал, хохирол нөхөн төлүүлэх шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо Дархан сумын ЗДТГ-ын эрх баригчид гаргана.

10.2 Гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх арга хэмжээ авна. Хэрэв гомдол гаргасан байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч, албан тушаалтны шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно.

#### **Арван найм. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

10.1 Энэ журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.


10.2. Мал амьтныг хашиж журамлахтай холбогдон гарсан зардлыг төлсөн нь захиргааны хариуцлага хүлээлгэхээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

#### **Арван ес. Журмын мөрдөх хугацаа**

Энэхүү журмыг 2021 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн Дархан сумын нутаг дэвсгэрт дагаж мөрдөнө.

ооооооОООооооооо

# Дархан сумын мал түр бэлчээрлэх бүсийн зураг



Д/д	Багийн нэр	Мал бэлчээрлэх талбайн хэмжээ /га/
1	6-р баг	792
2	7-р баг	46
3	8-р баг	412
4	15-р баг	822
5	Малчин баг	1522
<b>НИЙТ ДҮН</b>		<b>3594</b>

## Таних тэмдэг

- Мал түр бэлчээрлэх бүс
- 1-р баг
- 10-р баг
- 11-р баг
- 12-р баг
- 13-р баг
- 14-р баг
- 15-р баг
- 16-р баг
- 2-р баг
- 3-р баг
- 4-р баг
- 5-р баг
- 6-р баг
- 7-р баг
- 8-р баг
- 9-р баг
- Малчин
- Өргөө
- Барилга
- Нэгж талбар

1:45,000

Source: Esri, Maxar, GeoEye, Earthstar Geographics, CNES/Airbus DS, USDA, USGS, AeroGRID, IGN, and the GIS User Community

